


		Э.ПҮРЭВ-ЭРДЭНЭ ОРЧИН ҮЕИЙН АРХИТЕКТУРЫН ТҮҮХ (Сурах бичиг) 2019 он Архитектурын хөтөлбөрт ордог Орчин үеийн архитектурын түүх хичээлийн сургалтын төлөвлөгөөнд үндэслэн 1850-иад оноос хойших орчин үеийн хэмээн хүлээн зөвшөөрөгдсөн архитектурын бүтээл болон архитекторуудын талаар 3 бүлэг болгож энэхүү номд танилцуулсан. 17.12 х.х. ISBN: 978-99978-2-586-5
		Редактор: Э.ПҮРЭВ-ЭРДЭНЭ, С.АМГАЛАН (Орчуулгын бүтээл) ХОТ ТӨЛӨВЛӨЛТИЙН ҮНДЭС: ТӨСӨЛ БА ТӨЛӨВЛӨЛТӨД ЗОРИУЛСАН СУУРЬ МЭДЛЭГ 2013 он Хот төлөвлөлтийн талаар суурь ойлголт өгөх Проф.Др.Хелмүт Ботт нарын бүтээл болох тус номыг зохиогчийн албан ёсны зөвшөөрлийн дагуу Герман хэлнээс оруулан гарсан ба нийт 25 бүлгээс бүрдэнэ. Зөвхөн оюутан, суралцагч төдийгүй мэдлэгийн цар хүрээгээ тэлэх хүн бүрд зориулагдсан. 43,75 х.х. ISBN: 978-3930548-27-9

СУРАХ БИЧИГ БА НОМ


АРХИТЕКТУРЫН САЛБАР

АРХИТЕКТУРЫН ГРАФИК

орчуулсан А.ӨЭЛҮН

(мэргэжлийн ном)

2007 он



Архитектурын график мэргэжлийн номыг ШУТИС, БАС—ийн одоо мөрдөгдөж байгаа хөтөлбөрийн дагуу архитектурын оюутнууд, зураг төслийн байгууллагуудад ажиллаж байгаа архитектор, техникийн ажилтуудад зориулсан. Тухайн номонд хүн ба орон зайн систем, барилгын материалын график дүрслэл, архитектур зураглал ба перспектив дүрслэлийн график байгуулалтын үндсэн зарчим ба арга зүйг тайлбарласан болно.

ISBN 978-99929-3-042-X

МЭТТЮ ФРЕДЕРИК

АРХИТЕКТУРЫН СУРГУУЛЬД МИНИЙ СУРСАН 101 ЗҮЙЛ

орчуулсан А.ӨЭЛҮН, Э.БОЛОРЦЭЦЭГ

(мэргэжлийн ном)

УБ 2020 он



Номын зохиогч Мэттью Фредерик “Энэ бол архитектурын ангийн оюутнууд хичээлийн урландаа байлгаж, үүргэвчиндээ авч явахыг хүсэх ном юм. Мөн оюутнууд багш нарынхаа танилцуулснаас гадуур сэтгэж ангид яригддаг эргэлзээтэй зүйлсийг энгийн, ойлгомжтой хэлээр илэрхийлэх ном юм. “Зураас хэрхэн зурах” энгийн зүйлсээс эхлээд өнгөний онолын цогц ойлголт хүртэл төлөвлөлт, зураглал, танилцуулгын талаар товчилсон эдгээр 101 зүйл архитектурын сургалтын хөтөлбөрт ихэвчлэн тодорхойгүй, нээлттэй орхигддог асуудлуудыг тодорхой болгож архитектурын бичиг үсэгт нэвтрэхэд зайлшгүй шаардлагатай цагаан толгой болно. Оюутан

байхдаа иймэрхүү ном байдаг болоосой хэмээн хүсэж байсан архитектор төдийгүй сурган хүмүүжүүлэгчийн бичсэн Архитектурын сургуульд миний сурсан 101 зүйл архитектурын урлан хичээлийг чиглүүлэхэд үнэтэй зааварлагч болно. Төлөвлөлтийн эдрээтэй асуудал шийдвэрлэж буй хэн бүхэнд зориулж үндсэн ойлголтуудыг сэргээн зааварчлах энэхүү номыг залуу архитекторуудаас эхлээд туршлагатай мэргэжилтнүүд хүртэл архитектурын салбарын нийт төгсөгчид ч мөн уншиж судлах юм. Энэхүү ном нь архитектурын тухай чухал 10 номын жагсаалтад багтдаг бөгөөд Массачусетсийн технологийн дээд сургуулийн хэвлэлийн газрын албан ёсны зөвшөөрөлтэйгээр орчуулсан болно.

ISBN 978-9919-20-339-9



**Э.ПҮРЭВ-ЭРДЭНЭ
“СМАРТ СУУЦ” ЭРЧИМ ХҮЧНИЙ
ХЭМНЭЛТТЭЙ БАРИЛГА**

2020 он

ШУТИС-ийн Эрдэм Шинжилгээ Инновацийн Газраас зарласан **2IP** уралдаанд шалгарч тус төслийг иж бүрэн зураглал, төсвийн хамт гүйцэтгэсэн. Энэхүү төслийг гүйцэтгэхдээ нэг айлын бие даасан сууцны судалгаа, өмнө нь хийж байсан иргэдийн өөрсдийн барьсан сууц болон гэрийн дулаан алдагдлын судалгааг хамтатгахын зэрэгцээ технологийн хамгийн боломжит шийдлүүдийг зураг төсөлд тусгахыг эрмэлзсэн.

Барилгын дотор орон зайн цэвэр талбай-86,5м²

Л.ПҮРЭВ

**ЗУРАГ ЗУРАХ, БАРИМАЛ БАРИХ АРГА
АЖИЛЛАГАА**

2011 он

Архитектур, дизайны мэргэжлээр элсэгчид, мэргэжлийн ангийн оюутнуудад зориулав.

ISBN: 978-9919-20-382-5

20,25 х.х.






Скульптура Монголии (Нэгэн сэдэвт бүтээл)

УБ 2001 он

Энэхүү бүтээл нь монголын уран баримлын урлагийн түүхэн хөгжлийн талаар болон ардын урлагийн үндэс нь өнөөг хүртэл урлагийн язгуур үндэс болсон талаар өгүүлсэн болно. Их, дээд сургууль мэргэжлийн судлаачид, оюутнуудад зориулав.

Интерпресс хэвлэл.

ISBN 99929-5-375-6



Б.ДААЖАВ


ХҮМҮҮН ТӨРӨЛХТӨН БА МОНГОЛЧУУДЫН ОРШИХУЙН ТАВИЛАН

2011 он

Монголчууд хүний тухай яаж ийм ухааралд хүрсэн болон Ази, Европын эрдэм ухаан төгс бусад хүмүүс нийгмийн талаар ямар үзэл баримтлалтай байсан талаарх эх сурвалжуудыг харьцуулан жишиж үзсэн бүтээлээ уншигч олноо толилуулж байна.

ISBN: 978-99978-2-586-5

7.5 х.х.



Б.ДААЖАВ


**МОНГОЛЫН УРАН БАРИЛГЫН ТҮҮХ
/ТЭРГҮҮН ДЭВТЭР/**

2006 он

Энэхүү бүтээлд монголчуудын байгуулсан сэргээн засварласан, хуучин хот суурины дурсгалын одоо байгаа байршлыг тодруулах товч түүхэн баримтыг хавсаргасан болно.

ISBN: 99929-0-618-9

22,5 х.х.



Б.ДААЖАВ


**ГЭР-МОНГОЛ
УРАН-БАРИЛГЫН ҮНДЭС**

2006 он

Монгол гэрийн үүсэл, хувьслын түүхэн уламжлалыг задлан судлаж гэр нь өөрийн/ модуль/ суурь хэмжээний нэгжтэй ба тодорхой геометрийн дүрслэлийг босгох тэг зураглалтай болохыг гаргаж ирснээр Монголчуудын оюун соёлын өндөр түвшинд боловсруулсан сууц болохыг баталгаажуулсаны баримт болгон энэ бүтээлийг хийсэн болно.

ISBN: 99929-0-828-9

14,5 х.х.



Б.ДААЖАВ

**МОНГОЛЫН УРАН БАРИЛГЫН ТҮҮХ
/ДЭД ДЭВТЭР/**

2006 он

Энэ дэвтэрт XIV зууны Их Монгол улсын задарлын үеэс Монголын уламжлалт ханлиг овгийн засаг хаад, ноёдын эрх мэдлийг халсан 1923 он хүртэлх үеийн уран барилгын түүхийг хамааруусан болно.

ISBN: 99929-0-618-9

22,5 х.х.



Б.ДААЖАВ

**МОНГОЛ УРАН БАРИЛГЫН ТЭГ ЗОХИОХ
ҮНДЭСЛЭЛ**


/ГУТГААР ДЭВТЭР/

2006 он

Монголын уран барилга ч хэн боловч энэ асуудлыг хойш тавьж хэрэхэвч болохгүй билээ. Үүний учир өнөөгийн боломж, чадлын хэмжээнд ажсан, мэдсэн, судалсан зарим зүйлийг хойчийн үйлийг бодож уншигч, судлагч, мэргэдийн мэлмий сонорт хүргэх зорилгоор энэ асуудлыг дэвшүүлж байна.

ISBN: 99929-0-620-0

22,5 х.х.



Н.НЯМЖАВ


ХАР БА УРАН ЗУРАГ
(архитектур, интерьер дизайны сургалтанд зориулсан)

2018 он

Энэхүү сурах бичгийг ШУТИС-ийн Барилга, Архитектурын сургуулийн А6АР1320 архитектурын багцад элсэн хар зураг, уран зураг, иргэний барилгын интерьерийн хичээлүүдийг сонгож суралцагч архитектурын мэргэжлийн бакалаврын түвшинийн хөтөлбөрийн оюутны сургалтад зориулан бэлтгэв.

ISBN: 978-99962-869-5-7

20.5 х.х.





Н.НЯМЖАВ


БАРИЛГЫН ЗУРАГЗҮЙ
(Сурах бичиг)

2017 он

Уг номыг барилгын мэргэжлийн хичээлүүдийн сургалтын явцад зураг төслийн ажлыг гүйцэтгэх оюутанд зориулсан болно.

ISBN: 978-99973-3-249-3

	Ж. ГОМБО ХОЖИХУЙН ОНОЛ ба АМЬДРАХ ОРЧИН (Сурах бичиг) УБ- 2014он. Тус сурах бичгийг ШУТИС-БАС –н Архитектурын салбарын бакалавр, магистр доктор, оюутан, болон зураг төслийн байгууллагын мэрэгжилтэн болон хот төлөвлөлтийг сонирохдог хүмүүст зориулав. Тус сурах бичигт дэлхийн олон орны архитектор, хот төлөвлөгчдийн орчин үеийн онол, үзэл санаанаас гадна дэлхийн шилдэг бүтээн байгуулалтын олон жишээ орсон болно. ISBN 978-99973-67-56-3 Х.х.35,8
	Ж. ГОМБО ХОЖИХУЙН ОНОЛ ба АМЬДРАХ ОРЧИН (Сурах бичиг) УБ- 2019он. Тус сурах бичгийг ШУТИС-БАС –н Архитектурын салбарын бакалавр, магистр доктор, оюутан мөн зураг төслийн байгууллагын мэрэгжилтэн болон хот төлөвлөлтийг сонирохдог хүмүүст зориулав.Тус сурах бичигт дэлхийн олон орны архитектор хот төлөвлөгчдийн орчин үеийн онол, үзэл санаанаас гадна дэлхийн шилдэг бүтээн байгуулалтын сүүлийн үеийн олон жишээ орсон болно.Тус сурах бичиг нь 2014 онд анхны хэвлэлд нэмэлт өөрчлөлт оруулан шинэчилсэн 2 дах хэвлэл юм. ISBN 978-99973-67-56-3 х.х.38,4




**Д. БАТТОГТОХ, Б. ЖИГЖИД, Х.
ДАМЧААСҮРЭН**

ДҮРСЛЭХ ГЕОМЕТР
(Сурах бичиг)

УБ 2018 он

Их, дээд сургуулийн оюутанд зориулсан сурах
бичиг

ISBN 978-99978-4-477-4
х.х 21.3




Б. ЖИГЖИД
ШУГАМАН ДҮРСЛЭЛ
(Сурах бичиг)

УБ 2021 он

ЕБС-ийн 8-12 ангийн сурагчид зориулсан сурах
бичиг

ISBN 978-9919-24-397-5
х.х 21.8



Ч.ДАГШИГДОРЖ


АРХИТЕКТУРЫН ГРАФИК

(Сурах бичиг)

2009 он

Монгол Улсын Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуулийн Архитектур Зурагзүйн салбарт мөрдөж байгаа сургалтын стандартын дагуу, архитектурын мэргэжлээр эхлэн суралцаж буй бага курсын оюутнуудад архитектурын график ба зохиомжийн талаар суурь мэдлэг олгох зорилгоор боловсруулав.

ISBN: 978-99929-923-4-4



Ч.ДАГШИГДОРЖ

АРХИТЕКТУРЫН ЗОХИОМЖИЙН ҮНДЭС

(Сурах бичиг)

2009 он

Архитектор болох замыг сонгож авсан хэн бүхний нэн түрүүнд эзэмшвэл зохих зурах, бичихийн ухааныг үүний өмнөх “графикийн” хичээлээр үзэж, архитектурын графикийн арга, хэлбэрүүдийг өөрийн болгож чадсан аваас одоо цааш нь сэтгэн бодохын гүн ухаанд өөрийн авъяас билгээ дайчлан, үргэлжлүүлэн суралцах хоёр дахь шатандаа дэвшин орж буй оюутнуудад зориулж архитектурын “Зохиомжийн үндэс” хэмээх аргазүйн номыг толилуулж байна.

ISBN: 978-99929-923-5-2
